



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/134/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn

Дорноговь аймаг
Сайншанд сум
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа
Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Цахим хуудас: dornogovki@audit.gov.mn

2023.02.24 № 4-6/196

танай _____ -ны № _____ -т

САЙНШАНД СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 5-Р СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ч.БОЛДБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчлүүд тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, тохиолдсон байх, үнэн зөв байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Тус байгууллагын захирлын 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн Б/35 дугаар тушаалаар олгох үр дүнгийн урамшууллыг 11 ажилтанд давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.
- Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 12 дугаар сард үндсэн цалингийн 20 хувиар буюу нийт 0.2 сая төгрөгийг тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20-д "Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.18, 14.1.19-д зааснаас бусад төсвийн", 16 дугаар зүйлийн 16.5.2-т

01701943

"Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

- 2022 оны 8 дугаар сард 42 багшид ээлжийн амралтын хоног давхцуулж, ажиллуулан 6.9 сая төгрөгийн цалин, ажил олгогчоос төлсөн 0.9 сая төгрөгийн НДШ, нийт 7.8 сая төгрөгийг олгосон байна.
- Хүүхэд асрах чөлөөний хугацаа дуусч, 2022 оны 4 дүгээр сарын 11-ны өдрийн Б/22 тушаалаар эргэн ажилдаа томилогдсон ажилтны цалинг 21 хоногоор тооцон олгосноос 0.5 сая төгрөгийн цалин илүү олгосон байна.
- 1 ажилтанд А/23 дугаартай "Ажилчдын цалинг шинэчлэн тогтоох тухай" тушаалаар баталсан үндсэн цалинг 6-9 саруудад 0.2 сая төгрөгөөр илүү тооцон олгосон байна.
- Мөн 2 багшид ээлжийн амралтын хоногийг 52 хоногоор тооцон олгосноор 0.5 сая төгрөгийн цалин илүү олгосон байна.
- Тус сургуулийн захирлын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/26 дугаар тушаалаар Ахмадын сангийн журмыг шинэчлэн баталснаар, тухайн журмын 4.3. "Ахмад настнуудын 50-иас дээш хувийн хүсэлтээр идэвхтэй амралт зугаалгаар явах тохиолдолд жилд 1-2 удаа ирэх, буцах нийтийн унааны шатахууны зардлыг даана" заалтыг үндэслэж 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн А/27 дугаартай захирлын тушаалаар байгууллагын ахмад настан болон ажилчдын аяллын шатахууны зардал болон унааны түрээсэнд нийт 16.0 сая төгрөг зарцуулснаас 10.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыгхэрэгжүүлнэ, 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", ЗГ-ын 2017 оны 197 дугаар тогтоол "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 3 дугаар зүйл "Сангийн хөрөнгийн зарцуулалт"-д заасан 3.1.8. "ахмадуудын дунд идэвхтэй амралт, аялал, урлаг, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх";, 3.3. "Сангийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд ашиглах, зарцуулахыг хориглоно" заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх болон эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тус байгууллагын цалингийн зардал 1,335.1 сая төгрөг бөгөөд нийгмийн даатгалын байгууллагад 1,325.7 сая төгрөгөөр, татварын байгууллагад 1,300.0 сая төгрөгөөр тус тус тайлагнасан. Мөн 3-р сард 6.3 сая төгрөгийн цалингаас НДШ, ХХОАТ суутгалгүй олгосон байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1.цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, 25 дугаар зүйлийн 25.1.1.энэ хуулийн 14 дэх зүйлд заасан орлогын дүнд "энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1-т "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ:1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх; 2/шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх;" заалтуудтай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Үндсэн хөрөнгөд эргэлтийн хөрөнгө болох 8.6 сая төгрөгийн түрээсийн сурах бичгийг бүртгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.16 Бараа материалыг ангилж бүртгэхдээ

дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө" заалттай нийцэхгүй, ангилал болон ойлгомжтой байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллагын нягтлан бодогч нь байгууллагын цалингийн сангаас 2021-2022 оны 7 дугаар сарыг дуусталх хугацаанд 166.6 сая төгрөгийг Хаан банкны өөрийн нэр дээрх дансаар шилжүүлэн авч, албан тушаалаа урвуулан ашигласан хууль бус үйлдэл нь Дорноговь аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны Улсын ахлах байцаагчийн 2022 оны 24/01/24/03-114 тоот актаар тогтоогдсон тул тус сургуулийн захирлын 2022 оны 8 дугаар сарын 24-ны өдрийн Б/41 дүгээр тушаалаар тухайн ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцалж, хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн нь одоо хүртэл шийдэгдээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 2,829.9 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 2,258.9 сая төгрөгийн 53 гүйлгээ, 14.6 сая төгрөгийн 1 шийдвэрийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 376.6 сая төгрөгийн орлогын 8 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 43.9 сая төгрөгийн зарлагын 3 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 43.5 сая төгрөгийн 9 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ." 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"; заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Анхан шатны баримтын тулгалтаар 20 харилцагчдаас 22.1 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тооллого хийсэн баримтаас тооцоо бодсон актын үр дүнтэй тулган бүртгэлээрх эцсийн үлдэгдэл рүү хөөн шалгахад бараа материалын үлдэгдэл 33.1 сая төгрөгөөр

зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Байгууллагын захирлын 2022 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн А/01 дугаар тушаалаар 2022 оны бүтэц орон тоог баталсан бөгөөд цалин, цалингийн шатлал, нэмэгдлүүдийг баталж мөрдөөгүй, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, мэргэжлийн зэргийн нэмэгдэл, орон нутагт ажилласны нэмэгдлийн хувийг зөрүүтэйгээр тооцож олгосон, мөн 5-р сард үйлдвэрчний эвлэлийн татварыг 2%-иар тооцож цалингаас суутгасан байна. Ажилтан, албан хаагчдын 1, 2, 3, 6 дугаар саруудын цалин бодсон хүснэгт, цалин олгосон жагсаалт олдоогүй, хавсаргаагүй байна. Цалингийн тооцоог төрийн албаны цалингийн нэгдсэн системээс, программаас гарган ашигласан ба энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.3-т батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн "13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тайлант хугацаанд 2021 оны 9-12 сар, 2022 оны 1-6 сарын үр чадварыг олгосон байна. 2022 оны 9-12 сарын үр чадварын нэмэгдлийг олгоогүй ба 2023 онд олгохоор төлөвлөсөн ч бүртгэл тайланд өр төлбөрөөр тусгаагүй. 2022 оны 03 сарын 24-ны өдрийн А/09 болон 06 сарын 07-ны өдрийн А/23 дугаартай тушаалаар багш, ажилчдын цалинг шинэчлэн тогтоосон ба уг цалинг суурь болгосноор 2022 оны 1-6 сарын үр чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг илүү тооцож олгосон байна. Энэ нь Засгийн газрын 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 5 дахь заалт "Үр чадварын нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно.", НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.6 "14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.6.бүх зардал; заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дахин үнэлэгдсэн хөрөнгийн ашиглах жилийг зөрүүтэй бүртгэснээс хуримтлагдсан элэгдэл, элэгдлийн зардал алдаатай тооцогдсон байна. Энэ нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана", заалттай нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 11 зорилт, 30 арга хэмжээний хэрэгжилт 80.9 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 95.3 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т. ГАН-ӨЛЗИЙ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	227,178,325.79	372,028,788.11
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	132,308,717.32
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	132,308,717.32
3121	Төгрөг	-	132,308,717.32
31211	Төрийн сангийн харилцах	-	132,308,717.32
33	АВЛАГА	9,558,354.00	2,400,000.00
335	Бусад авлага	9,558,354.00	2,400,000.00
3351	Байгууллагаас авах авлага	9,558,354.00	2,400,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	217,619,971.79	237,320,070.79
351	Түүхий эд материал	1,929,250.00	1,346,600.00
35110	Тусгай зориулалттай материал	960,000.00	960,000.00
35130	Эм боох материал	969,250.00	386,600.00
354	Хангамжийн материал	215,690,721.79	235,973,470.79
35410	Бичиг хэргийн материал	7,047,129.00	15,824,132.00
35420	Аж ахуйн материал	68,663,428.94	70,296,179.94
35470	Бусад хангамжийн материал	139,980,163.85	149,853,158.85
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,927,100,634.76	1,871,221,737.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,927,100,634.76	1,871,221,737.10
392	Биет хөрөнгө	1,722,141,217.96	1,666,694,070.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,669,362,566.00	1,669,362,566.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(214,737,468.60)	(286,441,849.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	362,598,350.40	438,640,550.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(277,079,085.23)	(305,423,882.88)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	227,993,487.35	228,493,487.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	(160,397,631.61)	(185,898,968.66)
39209	Зам, гүүрийн байгууламж	97,723,671.06	97,723,671.06
39210	Хуримтлагдсан элэгдэл	(69,232,161.09)	(92,569,026.93)
39217	Ном	85,909,489.68	102,807,523.68
393	Биет бус хөрөнгө	204,959,416.80	204,527,666.88
39301	Програм хангамж	3,077,000.00	3,077,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,069,583.20)	(2,501,333.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	203,952,000.00	203,952,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,154,278,960.55	2,243,250,525.21
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,154,278,960.55	2,243,250,525.21
51	Засгийн газрын хувь оролцоо	2,154,278,960.55	2,243,250,525.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,498,640,057.09	2,498,640,057.09
512	Хуримтлагдсан үр дүн	(968,116,936.34)	(879,145,371.68)
51210	Өмнөх үеийн үр дүн	(968,116,936.34)	(965,650,603.34)
51220	Тайлант үеийн үр дүн	-	86,505,231.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	623,755,839.80	623,755,839.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,154,278,960.55	2,243,250,525.21

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,711,430,259.80	2,362,683,794.22
11	ТАТВАРЫН ОРЛОГО	16,048,654.94	31,265,582.00
110	Орлогын албан татвар	16,048,654.94	31,265,582.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	16,048,654.94	31,265,582.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,799,125.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,799,125.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,799,125.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,799,125.00
120017	Үнэ төлбөргүй авсан орлого-Үндсэн хөрөнгө	4,243,791.00	19,866,934.00
120018	Үнэ төлбөргүй авсан орлого-Бараа материал	11,804,863.94	4,202,148.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,695,381,604.86	2,329,619,087.22
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,429,515,800.00	2,018,696,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	45,420,000.00	2,018,696,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,384,095,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,944,244.00	2,010,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,944,244.00	2,010,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	248,921,560.86	308,912,287.22
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	248,921,560.86	308,912,287.22

2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,937,012,095.77	2,268,982,062.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,837,469,182.53	2,268,982,062.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,785,561,081.53	2,118,733,764.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,103,386,200.00	1,358,587,899.99
210101	Үндсэн цалин	612,217,423.00	1,033,649,434.52
210102	Нэмэгдэл	416,816,777.00	305,973,155.47
210104	Урамшуулал	74,352,000.00	18,965,310.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	179,942,300.00	239,011,901.69
210201	Тэтгэврийн даатгал	142,730,400.00	176,757,860.30
210202	Тэтгэмжийн даатгал	9,303,000.00	15,091,502.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,442,400.00	11,676,798.69
210204	Ажилгүйдлийн даатгал	1,860,600.00	2,950,917.79
210205	Эрүүл мэндийн даатгал	18,605,900.00	32,534,822.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	235,450,915.86	267,391,195.22
210301	Гэрэл, цахилгаан	5,640,802.86	12,090,205.22
210302	Түлш, халаалт	220,043,930.00	226,906,710.00
210303	Цэвэр, бохир ус	9,766,183.00	28,394,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,821,261.00	5,495,479.00
210401	Бичиг хэрэг	1,564,200.00	1,105,309.00
210402	Тээвэр, шатахуун	800,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	553,300.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,753,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,123,571.00	4,390,170.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	27,190.00	-
2105	Нормативт зардал	80,250.00	609,550.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,250.00	609,550.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	75,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,314,390.00	14,108,785.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,825,000.00	-
210604	Урсгал засвар	3,489,390.00	14,108,785.00
2107	Томилолт, зочны зардал	3,887,000.00	-
210702	Дотоод албан томилолт	3,887,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,055,700.00	7,279,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,148,500.00	1,410,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	907,200.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	5,869,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	241,623,064.67	226,249,753.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,539.00	72,448,147.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,345,529.00	4,482,475.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	237,271,996.67	149,319,131.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,908,101.00	150,248,298.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,946,035.00	150,248,298.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	39,936,035.00	148,248,298.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,010,000.00	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,558,354.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,558,354.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	403,712.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	403,712.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	99,542,913.24	-
2200	Дотоод эх үүсвэрээр	99,542,913.24	-
222001	Тоног төхөөрөмж	99,542,913.24	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(225,581,835.97)	93,701,731.66
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	841,568.67	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	26,074.67	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал	815,494.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(841,568.67)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(226,423,404.64)	93,701,731.66

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,695,739,704.86	2,353,890,099.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	15,026,858.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	15,026,858.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	15,026,858.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	12,560,525.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	2,466,333.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,695,739,704.86	2,338,863,241.22
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,429,515,800.00	2,018,696,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	45,420,000.00	2,018,696,800.00

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,384,095,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,302,344.00	11,254,154.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,302,344.00	11,254,154.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	248,921,560.86	308,912,287.22
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	248,921,560.86	308,912,287.22
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,630,312,704.86	2,221,581,381.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,630,312,704.86	2,221,581,381.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,578,398,558.86	2,068,915,783.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,103,312,800.00	1,396,720,361.90
210101	Үндсэн цалин	612,237,272.00	1,029,948,752.43
210102	Нэмэгдэл	416,723,527.77	334,076,322.47
210104	Урамшуулал	74,352,000.23	32,695,287.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	179,942,300.00	200,879,439.78
210201	Тэтгэврийн даатгал	142,730,400.00	136,919,941.63
210202	Тэтгэмжийн даатгал	9,303,000.00	16,157,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,442,400.00	12,911,456.26
210204	Ажилгүйдлийн даатгал	1,860,600.00	3,171,157.03
210205	Эрүүл мэндийн даатгал	18,605,900.00	31,719,884.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	235,450,915.86	267,391,195.22
210301	Гэрэл, цахилгаан	5,640,802.86	12,090,205.22
210302	Түлш, халаалт	220,043,930.00	226,906,710.00
210303	Цэвэр, бохир ус	9,766,183.00	28,394,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,314,055.00	-
210401	Бичиг хэрэг	2,540,090.00	-
210402	Тээвэр, шатахуун	800,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	553,300.00	-
210404	Ном, хэвлэл	295,400.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,759,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,366,265.00	-
2105	Нормативт зардал	2,760,500.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	999,300.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,761,200.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,852,145.00	7,992,995.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	-
210604	Урсгал засвар	13,852,145.00	7,992,995.00
2107	Томилолт, зочны зардал	3,887,000.00	-
210702	Дотоод албан томилолт	3,887,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,832,800.00	16,226,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,925,600.00	8,947,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	907,200.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	7,279,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,046,043.00	179,705,392.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	144,065,623.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,046,043.00	35,639,769.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,914,146.00	152,665,598.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,952,080.00	152,665,598.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	39,852,080.00	150,665,598.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.00	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,558,354.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,558,354.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	403,712.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	403,712.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	65,427,000.00	132,308,717.32
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	20,007,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,007,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	20,007,000.00	-
222001	Тоног төхөөрөмж	11,148,000.00	-
223001	Бусад хөрөнгө	8,859,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(20,007,000.00)	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	45,420,000.00	132,308,717.32
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	132,308,717.32

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,498,640,057.09	623,755,839.80	(968,116,936.34)	2,154,278,960.55
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,498,640,057.09	623,755,839.80	(968,116,936.34)	2,154,278,960.55
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,498,640,057.09	623,755,839.80	(968,116,936.34)	2,154,278,960.55
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,498,640,057.09	623,755,839.80	(968,116,936.34)	2,154,278,960.55
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,466,333.00	2,466,333.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,498,640,057.09	623,755,839.80	(965,650,603.34)	2,156,745,293.55
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	86,505,231.66	86,505,231.66
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,498,640,057.09	623,755,839.80	(879,145,371.68)	2,243,250,525.21

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,359,129,100.00	2,241,913,673.90	117,215,426.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,359,129,100.00	2,241,913,673.90	117,215,426.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,206,811,500.00	2,089,248,075.90	117,563,424.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,521,696,000.00	1,417,588,903.90	104,107,096.10
210101	Үндсэн цалин	1,137,571,200.00	1,050,692,294.43	86,878,905.57
210102	Нэмэгдэл	355,294,400.00	334,076,322.47	21,218,077.53
210104	Урамшуулал	28,830,400.00	32,820,287.00	(3,989,887.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	202,777,400.00	200,879,439.78	1,897,960.22
210201	Тэтгэврийн даатгал	137,888,600.00	136,919,941.63	968,658.37
210202	Тэтгэмжийн даатгал	16,222,200.00	16,157,000.00	65,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,977,700.00	12,911,456.26	66,243.74
210204	Ажилгүйдлийн даатгал	3,244,600.00	3,171,157.03	73,442.97
210205	Эрүүл мэндийн даатгал	32,444,300.00	31,719,884.86	724,415.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	275,592,300.00	267,391,195.22	8,201,104.78
210301	Гэрэл, цахилгаан	11,280,000.00	12,090,205.22	(810,205.22)
210302	Түлш, халаалт	233,252,300.00	226,906,710.00	6,345,590.00
210303	Цэвэр, бохир ус	31,060,000.00	28,394,280.00	2,665,720.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	7,992,995.00	7,005.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	7,992,995.00	7,005.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,096,200.00	16,226,400.00	10,869,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,947,200.00	8,947,200.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,149,000.00	7,279,200.00	10,869,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	171,649,600.00	179,169,142.00	(7,519,542.00)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	144,426,100.00	143,529,373.00	896,727.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,223,500.00	35,639,769.00	(8,416,269.00)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	152,317,600.00	152,665,598.00	(347,998.00)
2132	Бусад урсгал шилжүүлэг	152,317,600.00	152,665,598.00	(347,998.00)
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	152,317,600.00	150,665,598.00	1,652,002.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,000,000.00	(2,000,000.00)
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,359,129,100.00	2,374,222,391.22	(15,093,291.22)
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,018,696,800.00	2,018,696,800.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,018,696,800.00	2,018,696,800.00	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	317,120,500.00	308,912,287.22	8,208,212.78
132001	Орон нутгийн төсвөөс	317,120,500.00	308,912,287.22	8,208,212.78
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	23,311,800.00	46,613,304.00	(23,301,504.00)
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,947,200.00	8,947,200.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,364,600.00	5,916,275.00	8,448,325.00
120009	Бусад орлого		29,283,496.00	(29,283,496.00)
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө		2,466,333.00	(2,466,333.00)

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		132,308,717.32	(132,308,717.32)
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	85.00	84.00	1.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	59.00	58.00	1.00
620003	Үйлчлэх ажилтан	25.00	25.00	-
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,543.00	-	1,543.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1,543.00	-	1,543.00
630001	Төрийн өмчит ЕБС	1,543.00	-	1,543.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	11,254,154.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	11,254,154.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	8,451,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,451,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	8,451,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,302,954.00
213305	Нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл төвлөрүүлэлт	-	2,302,954.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	11,254,154.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	11,254,154.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	11,254,154.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 148.5 сая төгрөгийн 3 алдаа¹ илэрснээс аудитын явцад 148.5 сая төгрөгийн 3 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Үндсэн хөрөнгийн ашиглах жил тавигдаагүй 10 хөрөнгөд 2.6 сая төгрөгийн элэгдэл тооцоогүй, 1.7 сая төгрөгийн элэгдэл дутуу тооцсоныг, орлого үр дүнгийн тайлангийн элэгдэл нь тодруулгын элэгдлээс 2.7 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсаныг, нийт 7.0 сая төгрөгийн элэгдлийг залруулсан.
2. Буцаан төлөгдөх сурах бичгийн түрээсийн 8.9 сая төгрөг, гал тогоо болон заалны түрээсийн орлогын 50 хувь болох 1.5 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн данснаас үндсэн дансанд шилжүүлсэн 0.9 сая төгрөг, мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө хооронд шилжүүлсэн ахмадын сангийн 15.3 сая төгрөг, нийт 26.7 сая төгрөгийн орлогыг үр дүнгийн тайланд орлого, зарлагаар бүртгэснийг залруулсан.
3. Нийт 31 харилцагчаас 136.9 сая төгрөгийн ибаримт аваагүй байснаас 11 харилцагчаас 114.8 сая төгрөгийн ибаримтыг нөхөж авахуулсан.

Аудитаар нийт 13 зөрчил² илэрснээс, 9.2 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, 1 албан шаардлага хүргүүлж, 8 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

1. Тус байгууллагын захирлын 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн Б/35 дугаар тушаалаар үр дүнгийн урамшууллыг 6 дугаар сард бодож олгосон ба 2022 оны 7 дугаар сард 1.6 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг 11 ажилтанд давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2. Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 12 дугаар сард үндсэн цалингийн 20 хувиар буюу нийт 0.2 сая төгрөгийг тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.18, 14.1.19-д зааснаас бусад төсвийн”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.
3. 2022 оны 8 дугаар сард 42 багшид ээлжийн амралтын хоног давхцуулж, ажиллуулан 6.8 сая төгрөгийн цалин олгосон байна.
4. Мөн 2 багшид ээлжийн амралтын хоногийг 52 хоногоор тооцон олгосноор 0.5 сая төгрөгийн цалин илүү олгосон байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-т заасныг “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”-ыг үндэслэн төлбөрийн акт хүргүүлж байна.

3.2 Албан шаардлага

1. Ахмадын сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсантай холбоотой асуудал

Тус сургуулийн захирлын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/26 дугаар тушаалаар Ахмадын сангийн журмыг шинэчлэн баталснаар, тухайн журмын 4.3. “Ахмад настнуудын 50-иас дээш хувийн хүсэлтээр идэвхтэй амралт зугаалгаар явах тохиолдолд жилд 1-2 удаа ирэх, буцах нийтийн унааны шатахууны зардлыг даана” заалтыг үндэслэж 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн А/27 дугаартай захирлын тушаалаар байгууллагын аяллын шатахууны зардал болон унааны түрээсэнд нийт 16.0 сая төгрөг, үүнээс 10.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, шамшигдуулах, дутагдал үүсгэх үр дагавартай.

Тухайн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг ...хэрэгжүүлнэ, 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, ЗГ-ын 2017 оны 197 дугаар тогтоол “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 3 дугаар зүйл “Сангийн хөрөнгийн зарцуулалт”-д заасан 3.1.8. “ахмадуудын дунд идэвхтэй амралт, аялал, урлаг, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;”, 3.2. “Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, төсвийн шууд ерөнхийлөн захирагч энэхүү журмын 3.3. “Сангийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд ашиглах, зарцуулахыг хориглоно” заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх болон эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3 Зөвлөмж

1. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтын тулгалтаар 20 харилцагчдаас 22.1 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай.

Мөн үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн

нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг тооцоо хийгдсэн тухай бүрд нь цаасан болон цахим ибаримтыг үндэслэн санхүүгийн тайланд тусгаж ажиллах

2. Татвартай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын цалингийн зардал 1,335.1 сая төгрөг бөгөөд нийгмийн даатгалын байгууллагад 1,325.7 сая төгрөгөөр, татварын байгууллагад 1,300.0 сая төгрөгөөр тус тус тайлагнасан. Мөн 3-р сард 6.3 сая төгрөгийн цалингаас НДШ, ХХОАТ суутгалгүй олгосон байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1.цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, 25 дугаар зүйлийн 25.1.1.энэ хуулийн 14 дэх зүйлд заасан орлогын дүнд “энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1-т “Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ:1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх; 2/шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх;” заалтуудтай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татвар, нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, цалин хөлсийг холбогдох байгууллагуудад үнэн зөв тайлагнаж, үүссэн зөрүүг залруулах.

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тооллого хийсэн баримтаас тооцоо бодсон актын үр дүнтэй тулган бүртгэлээрх эцсийн үлдэгдэл рүү хөөн шалгахад бараа материалын үлдэгдэл 33.1 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, дутагдах үр дагавартай.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодогч жилийн тайланг гаргахын өмнө тооллогыг чанартай зохион байгуулж, тооллогын үр дүнг тооцож хариуцлагатай ажиллах.

4. Цалингийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын захирлын 2022 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн А/01 дугаар тушаалаар 2022 оны бүтэц орон тоог баталсан бөгөөд цалин, цалингийн шатлал, нэмэгдлүүдийг баталж мөрдөөгүй, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, мэргэжлийн зэргийн нэмэгдэл, орон нутагт ажилласны нэмэгдлийн хувийг зөрүүтэйгээр тооцож олгосон, мөн 5-р сард үйлдвэрчний эвлэлийн татварыг 2%-иар тооцож цалингаас суутгасан байна. Ажилтан, албан хаагчдын 1, 2, 3, 6 дугаар саруудын цалин бодсон хүснэгт, цалин олгосон жагсаалт олдоогүй, хавсаргаагүй байна. Цалингийн тооцоог төрийн албаны цалингийн нэгдсэн системээс, программаас гарган ашигласан ба энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.3-т батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн “13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн тушаалд албан тушаал, үндсэн цалин, цалингийн шатлал, нэмэгдлүүдийг тусгаж, тооцон баталгаажуулж, холбогдох хууль тогтоомжуудыг мөрдөж ажиллах

5. Цалингийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд 2021 оны 9-12 сар, 2022 оны 1-6 сарын ур чадварыг олгосон байна. 2022 оны 9-12 сарын ур чадварын нэмэгдлийг олгоогүй ба 2023 онд олгохоор төлөвлөсөн ч бүртгэл тайланд өр төлбөрөөр тусгаагүй. 2022 оны 03 сарын 24-ны өдрийн А/09 болон 06 сарын 07-ны өдрийн А/23 дугаартай тушаалаар багш, ажилчдын цалинг шинэчлэн тогтоосон ба уг цалинг суурь болгосноор 2022 оны 1-6 сарын ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг илүү тооцож олгосон байна. Энэ нь зардлыг цаг хугацаандаа бүртгээгүйгээс зардал бодитоор илэрхийлэгдэхгүй байх үр дагавартай.

Мөн Засгийн газрын 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 5 дахь заалт “Ур чадварын нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно.”, НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.6 “14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:, 14.4.6.бүх зардал; заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ур чадварын нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгох тухай ЗГ-ын 382-р тогтоолыг мөрдөж, НББ-ийн үнэн зөв байх, цаг хугацаандаа байх зарчмыг баримталж ажиллах.

6. Хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгөд эргэлтийн хөрөнгө болох 8.6 сая төгрөгийн түрээсийн сурах бичгийг бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.16 Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө” заалттай нийцэхгүй, ангилал болон ойлгомжтой байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг зөв ангилж, бүртгэлд үнэн зөв тусгаж ажиллах

7. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Дахин үнэлэгдсэн хөрөнгийн ашиглах жилийг зөрүүтэй бүртгэснээс хуримтлагдсан элэгдэл, элэгдлийн зардал алдаатай тооцогдсон байна. Энэ нь санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх, гарсан зардал цаг хугацаандаа тайлагнагдахгүй байх үр дагавартай.

Мөн УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана”, заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 49, 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

8. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 2,829.9 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 2,258.9 сая төгрөгийн 53 гүйлгээ, 14.6 сая төгрөгийн 1 шийдвэрийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 376.6 сая төгрөгийн орлогын 8 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 43.9 сая төгрөгийн зарлагын 3 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 43.5 сая төгрөгийн 9 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансанд холбогдох мэдээллүүдийг тогтоосон хугацаанд үнэн зөв, бүрэн оруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмж, албан шаардлагын биелэлтүүдийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн ашиглах жил тавигдаагүй 10 хөрөнгөд 2.6 сая төгрөгийн элэгдэл тооцоогүй, 1.7 сая төгрөгийн элэгдэл дутуу тооцсоныг, орлого үр дүнгийн тайлангийн элэгдэл нь тодруулгын элэгдлээс 2.7 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсаныг, нийт 7.0 сая төгрөгийн элэгдлийг залруулсан.	1	6,961.8			1	6,961.8	1	6,961.8				
Буцаан төлөгдөх сурах бичгийн түрээсийн 8.9 сая төгрөг, гал тогоо болон заалны түрээсийн орлогын 50 хувь болох 1.5 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн данснаас үндсэн дансанд шилжүүлсэн 0.9 сая төгрөг, мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө хооронд шилжүүлсэн ахмадын сангийн 15.3 сая төгрөг, нийт 26.7 сая төгрөгийн орлогыг үр дүнгийн тайланд орлого, зарлагаар бүртгэснийг залруулсан.	1	26,686.6			1	26,686.6	1	26,686.6				
Нийт 31 харилцагчаас 136.9 сая төгрөгийн ибаримт аваагүй байснаас 11 харилцагчаас 114.8 сая төгрөгийн ибаримтыг нөхөж авахуулсан.	1	114,777.9			1	114,777.9	1	114,777.9				
Дүн	3	148,426.3			3	148,426.3	3	148,426.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
			Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 2,829.9 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 2,258.9 сая төгрөгийн 53 гүйлгээ, 14.6 сая төгрөгийн 1 шийдвэрийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 376.6 сая төгрөгийн орлогын 8 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 43.9 сая төгрөгийн зарлагын 3 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 43.5 сая төгрөгийн 9 шийдвэрийг огт мэдээлээгүй байна.	1		-	-				1
Дүн	1		-	-				1

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Тус байгууллагын захирлын 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн Б/35 дугаар тушаалаар үр дүнгийн урамшууллыг 6 дугаар сард бодож олгосон ба 2022 оны 7 дугаар сард 1.6 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг 11 ажилтанд давхардуулан олгосон байна.	1	1,609.4	1	1,609.4									
Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 12 дугаар сард үндсэн цалингийн 20 хувиар буюу нийт 0.2 сая төгрөгийг тооцож олгосон байна.	1	236.5	1	236.5									
2022 оны 8 дугаар сард 42 багшид ээлжийн амралтын хоног давхцуулж, ажиллуулан 6.9 сая төгрөгийн цалин олгосон байна.	1	6806.5	1	6806.5									
Мөн 2 багшид ээлжийн амралтын хоногийг 52 хоногоор тооцон олгосноор 0.5 сая төгрөгийн цалин илүү олгосон байна.	1	533.3	1	533.3									
Тус сургуулийн захирлын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/26 дугаар тушаалаар Ахмадын сангийн журмыг шинэчлэн баталснаар, тухайн журмын 4.3. "Ахмад настнуудын 50-иас дээш хувийн хүсэлтээр идэвхтэй амралт зугаалгаар явах тохиолдолд жилд 1-2 удаа ирэх, буцах нийтийн унааны шатахууны зардлыг даана" заалтыг үндэслэж 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн А/27 дугаартай захирлын тушаалаар байгууллагын	1	10,684.8			1	10,684.8							

бүртгэл тайланд өр төлбөрөөр тусгаагүй. 2022 оны 03 сарын 24-ны өдрийн А/09 болон 06 сарын 07-ны өдрийн А/23 дугаартай тушаалаар багш, ажилчдын цалинг шинэчлэн тогтоосон ба уг цалинг суурь болгосноор 2022 оны 1-6 сарын ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг илүү тооцож олгосон байна.												
Үндсэн хөрөнгөд эргэлтийн хөрөнгө болох 8.6 сая төгрөгийн түрээсийн сурах бичгийг бүртгэсэн байна.	1	8,570.8					1	8,570.8				
Дахин үнэлэгдсэн хөрөнгийн ашиглах жилийг зөрүүтэй бүртгэснээс хуримтлагдсан элэгдэл, элэгдлийн зардал алдаатай тооцогдсон байна.	1						1					
Дүн	12	28,441.3	4	9185.6	1	10,684.8	7	8,570.8				